БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 25 өдөр Дугаар А/384 Булган сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, "Улсын хэмжээнд 2026 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2026 оны 45 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын 6 дугаар баг, Залуусын 14 дүгээр гудамжны 1424 тоот хаягт байршилтай, 5150229 төлөвлөлтийн дугаартай, амины орон сууцны зориулалттай 699 м² талбай бүхий газрыг иргэн П.Соёлмаа (ГЕ84022941)-д, Булган сумын 6 дугаар баг, Залуусын 14 дүгээр гудамжны 1426 тоот хаягт байршилтай, 5150228 төлөвлөлтийн дугаартай, амины орон сууцны зориулалттай 579 м² талбай бүхий газрыг иргэн Д.Одхүү (Е391040918)-д тус тус 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Иргэн П.Соёлмаа, Д.Одхүү нартай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшиж, ашиглахыг газар эзэмшигч иргэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2026 едер бүр 6326010544